ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/5/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@auditgov.mn<br>Аудитын менежер: Ц.Хосжаргал<br>Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn<br>Ахлах аудитор:В.Эрдэнэцогт<br>Утас: 261628 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/330

танай ____________-ны № ____________-т

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Ш.АЛТАНТУЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 528,041.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- Хандив, тусламж болон улсын төсвийн хөрөнгөөр барьсан барилгыг данс бүртгэлд тусгаагүй, барилга байгууламжийн зориулалтыг өөрчилсөн, түрээсийн талбайн хэмжээг дутуу тогтоосон, түрээслэгч нараас ашиглалтын зардлыг тооцож аваагүй, элэгдлээ байгуулж дууссан хөрөнгийг дахин үнэлээгүй зэрэг үндсэн хөрөнгийн ашиглалт, сайжруулалттай холбоотой 574,106.7 мянган төгрөг;
- Төлбөртэй ор хоногийн тооцоог хийгээгүй 106,720.0 мянган төгрөг;
- Худалдан авах ажиллагааны аргыг сонгохдоо босго үнийг баримтлаагүй 75,864.2
- мянган төгрөг;
- Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй 163,476.6 мянган төгрөг зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Төрийн өмчийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан

авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасантай, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хүүхдийн цээж ба хэвлийн дурангийн мэс заслын аргыг өргөжүүлж “Монгол улсад хүүхэд нярайн дурангийн мэс заслын тусламжийг сайжруулах-II” уулзалтыг зохион байгуулж, уулзалтад ирсэн гадаадын эмч, сувилагч нартай 7 хоног хамтран ажиллах хугацаандаа 17 хүүхдэд мэс засал эмчилгээг амжилттай хийсэн байна.

Тайвны Хүүхэд гэр бүлийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй ”Хязгаар нутгийн инээмсэглэл” төслийн хүрээнд 5 орон нутгийн эмнэлэгтэй хамтран ажиллаж нийт 444 үзлэг хийж, 110 мэс засал, хэл яриа засал болон гажиг заслын үзлэг 238 хүүхэд тусламж үйлчилгээ үзүүлж, орон нутаг 484 эмч эмнэлгийн тусгай мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Нэгдсэн үндэсний байгууллагын хөрөнгө оруулалтаар 3 ширхэг 62,677.2 мянган төгрөгийн үнэтэй халуун барьдаг хоолны зөөврийн тэрэг бэлтгэжээ. Үүний үр дүнд Эх барих эмэгтэйчүүдийн эрсдэлтэй жирэмсэн судлалын тасагт QR кодоор хоол олгох ажлыг нэвтрүүлж, халуун хоолыг цаг алдалгүй хүргэдэг болсон байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд буцалтгүй болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 1,541,521.5 мянган төгрөгийн үнэтэй Хавдрын эрт илрүүлэхийн төвийн барилга, тоног төхөөрөмжийг шинээр ашиглалтад оруулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг төлөвлөснөөс гүйцэтгэлийг 97.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,059,679,830.41** | **10,896,391,989.01** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **3,791,015,197.14** | **515,592,896.23** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **3,791,015,197.14** | **515,592,896.23** |
| **31210** | **Төгрөг** | **3,791,015,197.14** | **515,592,896.23** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 3,790,995,551.99 | 515,577,451.08 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 19,645.15 | 15,445.15 |
| **33** | **АВЛАГА** | **4,690,398,811.09** | **5,977,135,411.50** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 39,368,918.35 | 19,053,716.50 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 4,600,000,000.00 | 5,805,069,397.00 |
| **33500** | **Бусад авлага** | **51,029,892.74** | **153,012,298.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 51,029,892.74 | 153,012,298.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **4,578,265,822.18** | **4,403,663,681.28** |
| **35100** | **Түүхий эд материал** | **4,406,996,587.84** | **4,204,797,227.99** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,946,185,386.01 | 2,979,200,548.39 |
| 35130 | Эм боох материал | 1,460,811,201.83 | 1,225,596,679.60 |
| **35400** | **Хангамжийн материал** | **171,269,234.34** | **198,866,453.29** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 43,643,112.84 | 9,155,826.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 30,652,112.09 | 47,065,039.85 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 17,842,490.41 | 23,674,473.44 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,170,000.00 | 7,680,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 65,000.00 | 0.00 |
| 35460 | Хүнсний материал | 42,952,840.00 | 81,347,435.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 29,943,679.00 | 29,943,679.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **59,484,823,717.77** | **65,137,813,357.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **59,484,823,717.77** | **65,137,813,357.17** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **53,280,135,217.77** | **58,933,124,857.17** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 40,201,026,149.46 | 49,769,707,673.16 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (5,599,396,935.26) | (7,146,957,067.64) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 537,270,521.00 | 537,270,521.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (388,103,071.39) | (423,607,413.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 53,746,503,201.77 | 53,651,759,535.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (36,273,122,382.57) | (38,398,791,256.56) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 2,552,087,804.73 | 2,615,104,743.73 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (1,505,434,619.97) | (1,680,666,428.15) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 568,544,247.56 | 568,544,247.56 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (568,544,247.56) | (568,544,247.56) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 9,304,550.00 | 9,304,550.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **6,204,688,500.00** | **6,204,688,500.00** |
| 39301 | Програм хангамж | 287,613,849.48 | 287,513,849.48 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (287,613,849.48) | (287,513,849.48) |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,204,688,500.00 | 6,204,688,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **72,544,503,548.18** | **76,034,205,346.18** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **364,222,869.35** | **4,913,027,895.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **364,222,869.35** | **4,913,027,895.00** |
| **41300** | **Өглөг** | **364,222,869.35** | **4,913,027,895.00** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 59,600,380.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **361,476,908.35** | **4,853,427,515.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 361,476,908.35 | 4,853,427,515.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **72,180,280,678.83** | **71,121,177,451.18** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **72,180,280,678.83** | **71,121,177,451.18** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 19,625,186,499.80 | 19,625,186,499.80 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 19,625,186,499.80 | 19,625,186,499.80 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **22,916,971,143.15** | **21,857,867,915.50** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 15,507,459,648.95 | 22,916,971,143.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 7,409,511,494.20 | (1,059,103,227.65) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 29,638,123,035.88 | 29,638,123,035.88 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **72,544,503,548.18** | **76,034,205,346.18** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **60,213,668,495.67** | **61,439,809,495.23** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,787,104,514.87** | **12,467,886,273.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **10,787,104,514.87** | **12,467,886,273.66** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **923,025,440.00** | **1,130,563,301.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 834,826,866.00 | 903,326,828.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 88,198,574.00 | 227,236,473.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 8,616,027,716.08 | 10,685,928,491.70 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,248,051,358.79 | 651,394,480.96 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **49,426,563,980.80** | **48,971,923,221.57** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,748,344,788.80** | **3,589,499,664.57** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 889,655,425.00 | 982,824,777.94 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,857,816,863.80 | 2,606,674,886.63 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 872,500.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **45,678,219,192.00** | **45,382,423,557.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 45,678,219,192.00 | 45,382,423,557.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **52,804,157,001.47** | **62,498,593,866.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **52,804,157,001.47** | **62,498,593,866.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **51,094,821,843.47** | **61,003,703,364.18** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **24,329,293,569.25** | **31,159,590,103.72** |
| 210101 | Үндсэн цалин | 14,522,449,818.25 | 17,185,947,612.62 |
| 210102 | Нэмэгдэл | 7,163,932,963.00 | 10,616,355,169.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,097,755,000.00 | 1,075,705,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,545,155,788.00 | 2,281,582,322.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,012,575,103.25** | **3,904,640,964.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,087,408,477.45 | 2,738,603,863.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 245,482,366.57 | 308,091,863.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 193,318,064.37 | 246,473,778.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 44,075,422.35 | 55,361,436.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 442,290,772.51 | 556,110,024.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,663,150,503.98** | **1,807,498,016.34** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 616,823,754.33 | 801,320,209.12 |
| 210302 | Түлш, халаалт | 282,288,711.65 | 539,492,636.54 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 764,038,038.00 | 466,685,170.68 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **654,208,002.69** | **817,178,884.49** |
| 210401 | Бичиг хэрэг | 95,794,275.77 | 157,954,809.45 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,707,458.31 | 45,320,088.52 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,254,553.49 | 24,633,336.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 440,123,032.45 | 519,158,883.26 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 54,328,682.67 | 70,111,766.66 |
| **2105** | **Нормативт зардал** | **13,747,452,751.30** | **15,429,121,690.63** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,218,808,614.55 | 13,713,414,063.40 |
| 210502 | Хоол, хүнс | 1,244,971,040.10 | 1,442,972,957.60 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 283,673,096.65 | 272,734,669.63 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **586,044,210.95** | **799,986,394.95** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 115,390,513.86 | 148,449,898.84 |
| 210604 | Урсгал засвар | 470,653,697.09 | 651,536,496.11 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **264,772,353.00** | **285,922,691.62** |
| 210701 | Гадаад албан томилолт | 10,910,700.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 253,861,653.00 | 285,922,691.62 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **162,798,278.31** | **78,572,907.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 127,613,521.00 | 43,832,682.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 13,300,000.00 | 13,300,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,105,582.00 | 4,732,202.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 308,000.00 | 308,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 16,576,022.00 | 16,325,417.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 137,874.00 | 74,606.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 757,279.31 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,674,527,070.74** | **6,721,191,711.43** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 486,656,136.96 | 193,691,380.83 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 71,332,500.00 | 51,120,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,116,538,433.78 | 6,476,379,730.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,709,335,158.00** | **1,494,890,502.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,709,335,158.00** | **1,494,890,502.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 641,081,921.00 | 1,321,767,414.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,068,253,237.00 | 173,123,088.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **7,409,511,494.20** | **(1,058,784,370.95)** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **318,856.70** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | - | 318,856.70 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **7,409,511,494.20** | **(1,059,103,227.65)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **51,236,923,704.21** | **48,898,395,139.55** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,716,663,784.71** | **1,131,541,314.98** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **4,716,663,784.71** | **1,131,541,314.98** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **4,716,663,784.71** | **1,131,541,314.98** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 832,053,076.00 | 903,326,828.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,884,610,708.71 | 228,214,486.98 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **46,520,259,919.50** | **47,766,853,824.57** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **3,589,499,664.57** |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | - | 982,824,777.94 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,606,674,886.63 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **46,520,259,919.50** | **44,177,354,160.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 46,520,259,919.50 | 44,177,354,160.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **47,713,602,713.38** | **50,754,557,699.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **47,713,602,713.38** | **50,754,557,699.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **46,011,058,555.38** | **49,249,968,965.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **24,697,577,564.77** | **29,356,072,757.44** |
| 210101 | Үндсэн цалин | 13,581,360,224.78 | 13,410,419,559.77 |
| 210102 | Нэмэгдэл | 8,519,790,958.75 | 12,277,729,335.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,071,344,334.48 | 1,069,289,832.65 |
| 210104 | Урамшуулал | 1,525,082,046.76 | 2,598,634,029.51 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,284,031,883.64** | **3,493,467,005.35** |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,958,843,510.63 | 2,448,245,673.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 77,706,072.85 | 258,338,491.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 64,117,882.53 | 219,045,079.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,509,430.16 | 53,175,709.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 166,854,987.47 | 514,662,050.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,857,364,941.39** | **1,835,141,867.62** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 666,238,369.04 | 802,518,636.41 |
| 210302 | Түлш, халаалт | 356,178,700.35 | 498,945,087.53 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 834,947,872.00 | 533,678,143.68 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **621,398,227.49** | **693,795,698.60** |
| 210401 | Бичиг хэрэг | 87,677,339.00 | 75,659,918.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,000,000.00 | 47,100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,254,553.49 | 22,433,336.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 403,886,546.00 | 441,641,221.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 79,579,789.00 | 106,961,223.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **14,008,660,533.37** | **12,645,611,562.15** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,407,010,533.37 | 10,763,494,257.15 |
| 210502 | Хоол, хүнс | 1,279,464,000.00 | 1,495,251,960.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 322,186,000.00 | 386,865,345.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **501,740,822.72** | **402,448,009.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 94,483,800.00 | 43,325,485.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,235,000.00 | 2,840,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 405,022,022.72 | 356,282,524.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **266,240,833.00** | **268,186,166.30** |
| 210702 | Дотоод албан томилолт | 266,240,833.00 | 268,186,166.30 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **141,695,049.00** | **160,205,684.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 72,472,071.00 | 92,326,617.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 13,300,000.00 | 13,300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,892,000.00 | 3,495,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,213,582.00 | 1,236,982.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 308,000.00 | 308,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 16,576,022.00 | 16,325,417.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 197,874.00 | 71,948.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 34,735,500.00 | 33,141,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **632,348,700.00** | **395,040,215.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 562,490,200.00 | 333,910,415.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 69,858,500.00 | 61,129,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,702,544,158.00** | **1,504,588,734.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,702,544,158.00** | **1,504,588,734.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 641,081,921.00 | 1,321,767,414.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,061,462,237.00 | 182,821,320.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **3,523,320,990.83** | **(1,856,162,559.91)** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **70,815,130.00** | **1,419,259,735.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **70,815,130.00** | **1,419,259,735.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **70,815,130.00** | **1,419,259,735.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 70,815,130.00 | 1,419,259,735.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(70,815,130.00)** | **(1,419,259,735.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **3,452,505,860.83** | **(3,275,422,294.91)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 338,509,336.31 | 3,791,015,197.14 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,791,015,197.14 | 515,592,896.23 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **19,625,186,499.80** | **29,638,123,035.88** | **15,507,459,648.95** | **64,770,769,184.63** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 19,625,186,499.80 | 29,638,123,035.88 | 15,507,459,648.95 | 64,770,769,184.63 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 7,409,511,494.20 | 7,409,511,494.20 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **19,625,186,499.80** | **29,638,123,035.88** | **22,916,971,143.15** | **72,180,280,678.83** |
| **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **19,625,186,499.80** | **29,638,123,035.88** | **22,916,971,143.15** | **72,180,280,678.83** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **19,625,186,499.80** | **29,638,123,035.88** | **22,916,971,143.15** | **72,180,280,678.83** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тайлант үеийн үр дүн | - | - | (1,059,103,227.65) | (1,059,103,227.65) |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **19,625,186,499.80** | **29,638,123,035.88** | **21,857,867,915.50** | **71,121,177,451.18** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **57,107,654,800.0** | **52,173,817,434.5** | **4,933,837,365.5** | **91.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **57,107,654,800.0** | **52,173,817,434.5** | **4,933,837,365.5** | **91.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **55,444,586,300.0** | **50,669,228,700.5** | **4,775,357,599.5** | **91.4** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **31,153,442,700.0** | **29,356,072,757.4** | **1,797,369,942.6** | **94.2** |
| 210101 | Үндсэн цалин | 15,549,406,800.0 | 13,410,419,559.8 | **2,138,987,240.2** | **86.2** |
| 210102 | Нэмэгдэл | 11,522,563,400.0 | 12,277,729,335.5 | **(755,165,935.5)** | **106.6** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,187,510,000.0 | 1,069,289,832.7 | **118,220,167.4** | **90.0** |
| 210104 | Урамшуулал | 2,893,962,500.0 | 2,598,634,029.5 | **295,328,470.5** | **89.8** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,891,001,800.0** | **3,493,467,005.4** | **397,534,794.7** | **89.8** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,644,140,400.0 | 2,448,245,673.1 | **195,894,726.9** | **92.6** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 311,735,700.0 | 258,338,491.9 | **53,397,208.1** | **82.9** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 249,388,600.0 | 219,045,079.8 | **30,343,520.2** | **87.8** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 62,347,200.0 | 53,175,709.7 | **9,171,490.3** | **85.3** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 623,389,900.0 | 514,662,050.9 | **108,727,849.1** | **82.6** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,734,007,200.0** | **1,835,141,867.6** | **(101,134,667.6)** | **105.8** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 805,344,600.0 | 802,518,636.4 | **2,825,963.6** | **99.6** |
| 210302 | Түлш, халаалт | 463,662,600.0 | 498,945,087.5 | **(35,282,487.5)** | **107.6** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 465,000,000.0 | 533,678,143.7 | **(68,678,143.7)** | **114.8** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **697,560,900.0** | **693,795,698.6** | **3,765,201.4** | **99.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 63,177,000.0 | 75,659,918.0 | **(12,482,918.0)** | **119.8** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,000,000.0 | 47,100,000.0 | **(2,100,000.0)** | **104.7** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 25,433,900.0 | 22,433,336.6 | **3,000,563.4** | **88.2** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 455,000,000.0 | 441,641,221.0 | **13,358,779.0** | **97.1** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 108,950,000.0 | 106,961,223.0 | **1,988,777.0** | **98.2** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **15,015,496,300.0** | **12,645,611,562.2** | **2,369,884,737.9** | **84.2** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,175,960,800.0 | 10,763,494,257.2 | **2,412,466,542.9** | **81.7** |
| 210502 | Хоол, хүнс | 1,510,540,800.0 | 1,495,251,960.0 | **15,288,840.0** | **99.0** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 328,994,700.0 | 386,865,345.0 | **(57,870,645.0)** | **117.6** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,828,956,400.0** | **1,695,754,964.0** | **133,201,436.0** | **92.7** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,453,791,700.0 | 1,332,232,440.0 | 121,559,260.0 | 91.6 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,000,000.0 | 2,840,000.0 | 4,160,000.0 | 40.6 |
| 210604 | Урсгал засвар | 368,164,700.0 | 360,682,524.0 | 7,482,176.0 | 98.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **272,376,200.0** | **268,186,166.3** | **4,190,033.7** | **98.5** |
| 210702 | Дотоод албан томилолт | 272,376,200.0 | 268,186,166.3 | **4,190,033.7** | **98.5** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **155,439,800.0** | **160,205,684.0** | **(4,765,884.0)** | **103.1** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,660,000.0 | 92,326,617.0 | (21,666,617.0) | 130.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 13,300,000.0 | 13,300,000.0 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,500,000.0 | 3,495,220.0 | 4,780.0 | 99.9 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,733,600.0 | 1,236,982.0 | 496,618.0 | 71.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 500,000.0 | 308,000.0 | 192,000.0 | 61.6 |
| 210807 | Газрын төлбөр | 16,636,300.0 | 16,325,417.0 | **310,883.0** | **98.1** |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300,000.0 | 71,948.0 | 228,052.0 | 24.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 48,809,900.0 | 33,141,500.0 | 15,668,400.0 | 67.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **696,305,000.0** | **520,992,995.0** | **175,312,005.0** | **74.8** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 633,755,700.0 | 459,863,195.0 | **173,892,505.0** | **72.6** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 62,549,300.0 | 61,129,800.0 | 1,419,500.0 | 97.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,663,068,500.0** | **1,504,588,734.0** | **158,479,766.0** | **90.5** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,663,068,500.0** | **1,504,588,734.0** | **158,479,766.0** | **90.5** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,546,617,500.0 | 1,321,767,414.0 | 224,850,086.0 | 85.5 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 116,451,000.0 | 182,821,320.0 | (66,370,320.0) | 157.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **57,107,654,800.0** | **48,921,717,342.7** | **8,185,937,457.3** | **85.7** |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **47,908,499,200.0** | **44,074,011,843.0** | **3,834,487,357.0** | **92.0** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 47,908,499,200.0 | 44,074,011,843.0 | 3,834,487,357.0 | 92.0 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **9,199,155,600.0** | **4,847,705,499.7** | **4,351,450,100.3** | **52.7** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 976,964,600.0 | 1,017,736,310.9 | (40,771,710.9) | 104.2 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,431,195,400.0 | 3,829,969,188.8 | 601,226,211.2 | 86.4 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 3,790,995,600.0 | - | 3,790,995,600.0 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 3,767,677,542.88 | (3,767,677,542.9) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 515,577,451.08 | (515,577,451.1) | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1.0** | **-** | **1.0** | **-** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.0** | **-** | **1.0** | **-** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | **100.0** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 1,145 | 1,025 | 120.0 | **89.5** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | **100.0** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 759 | 704 | 55.0 | **92.8** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 385 | 320 | 65.0 | **83.1** |
| 620004 | Гэрээт ажилтан | - | - | **-** | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

Аудитаар нийт 4,519,329.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулаа.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нярайн дурангийн мэс заслын багажийг эд ангиудаар салгаж жижиглэн бүртгэсэн. | 1 | 356,509.9 | | | 1 | 356,509.9 | 1 | 356,509.9 | | | | |
| Үр дүнгийн тайланд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 2,606,674.9 мянган төгрөгийн орлогыг хандивын орлогоор буруу тайлагнасан. | 1 | 2,606,674.9 | | | 1 | 2,606,674.9 | 1 | 2,606,674.9 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд 982,824.8 мянган төгрөгийн төслийн санхүүжилтийг дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан орлогоор буруу тайлагнасан. | 1 | 982,824.8 | | | 1 | 982,824.8 | 1 | 982,824.8 | | | | |
| Худалдан авсан бараа материалыг 33,544.9 мянган төгрөг, шилжүүлэн авсан засварын материалыг 1,919.5 мянган төгрөгөөр тус тус дутуу, дотоод шилжүүлгээр тасгуудад олгосон 537,855.2 мянган төгрөгийн хангамжийн материалыг зарцуулснаар тайлагнасан. | 1 | 573,319.6 | | | 1 | 573,319.6 | 1 | 573,319.6 | | | | |
| **Дүн** | **4** | **4,519,329.2** | | | | | **4** | **4,519,329.2** | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 1,225,506.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 907,828.9 мянган төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 317,677.1 мянган төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний төлбөрийг шууд зардлаар бүртгэсэн. | 1 | 3,495.2 | | | | | 1 | 3,495.2 | | | | |
| Жилийн эцэст 19,653.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй. Үүнээс ажиллагсдаас авах 1,972.2 мянган төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй. | 1 | 19,653.7 | | | | | 1 | 19,653.7 | | | | |
| Жилийн эцэст 143,822.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй. | 1 | 143,822.9 | | | | | 1 | 143,822.9 | | | | |
| Цалингаас суутган тооцсон татварын өр төлбөрийн үлдэгдэл нь ХХОАТ-ын тайлангаас 48,128.4 мянган төгрөгөөр илүү байна. | 1 | 48,128.4 | | | | | 1 | 48,128.4 | | | | |
| 2023 онд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 546,102.9 мянган төгрөгөөр баригдсан Хүчил төрөгчийн үйлдвэрийн барилгыг данс бүртгэлд тусгаагүй. | 1 | 546,102.9 | | | 1 | 546,102.9 | | | | | | |
| Төрийн бус байгууллагын хөрөнгө оруулалтаар баригдсан Ажаа гэгээний барилга гэсэн барилгыг данс бүртгэлд тусгаагүй. | 1 | - | | | 1 | - | | | | | | |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Байгууллагын эзэмшил газрын кадастр нь "Гурван гал хувийн эмнэлэг"-ийн үүдний хэсгийн газартай давхацсан, тус хувийн эмнэлгийн автомашины зогсоол нь ЭХЭМҮТ-ийн газарт байрлаж байгаа нь газраа алдах эрсдэлтэй, түрээс төлдөггүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 5,292.6 мянган төгрөгийн дансны үнэтэй манаачийн байр № 1-ийг ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр буулгаж, хувийн компани 120.м.кв талбайтай цайны газрын барилга барьж, 2008 оноос хойш үйл ажиллагаа явуулж ирсэн байна.Тус цайны газартай сар бүр 12 м.кв-аар тооцож, 480.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төлөх гэрээ байгуулж хувийн хэвшилд давуу байдал олгосон. | 1 | 5,292.6 | | | 1 | 5,292.6 | | | | | | |
| Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 5,292.6 мянган төгрөгийн дансны үнэтэй манаачийн байр №2-ыг засварлаж, төрийн өмчийн зориулалтыг өөрчлөн хувь хүнд хүнсний дэлгүүрийн зориулалтаар ашиглуулж байгаа бөгөөд түрээсийн гэрээ байгуулаагүй, төлбөр авдаггүй байна. | 1 | 5,292.6 | | | 1 | 5,292.6 | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 17,418.6 мянган төгрөгийн 1338 ширхэг хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдээгүй байна. | 1 | 17,418.6 | | | | | 1 | 17,418.6 | | | | |
| ТӨБЗГ болон түрээслэгч нартай байгуулсан 6 түрээсийн гэрээнд цахилгаан дулаан, цэвэр ус зэрэг ашиглалтын зардал нь түрээсийн төлбөрт багтаагүй, түрээслэгч өөрөө төлөхөөр заасан боловч тоолуур тавиагүй, ашиглалтын зардлын тооцоог хийдэггүй, зардлыг төсвөөс төлсөн. | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үр хөндөлтийн төлбөрөөс ЭХЭМҮТ-ийн захирлын 2012 оны 66 дугаар тушаалаар баталсан "Жирэмсний эрт үеийн үр хөндөлтийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам"-ын орлогын 45.0 хувийг дагуу эмч, сувилагч нарт олгох тооцоо үүсгээгүй, өөрийн орлогоор хүлээн зөвшөөрч, цалингийн зардлаас эмч сувилагч нарт тухайн нэмэгдлийг олгосон. | 1 | 43,658.3 | | | | | 1 | 43,658.3 | | | | |
| Нийт 14 тасгийн төлбөртэй өрөөний орлого төвлөрүүлэлтэд хяналт хэрэгжүүлээгүй, тооцоо бодоогүй. | 1 | 106,720.0 | | | 1 | 106,720.0 | | | | | | |
| Дутуу тээлт судлалын тасаг 70.0 мянга, ерөнхий мэс заслын тасаг 120.0 мянга, чих хамар хоолойн мэс заслын тасаг 90.0 мянга, эрүү нүүрний мэс заслын тасаг 340.0 мянга, нийт 620.0 мянган төгрөгийн төлбөртэй өрөөний орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн. | 1 | 620.0 | | | 1 | 620.0 | | | | | | |
| ЭХЭМҮТ-ийн захирлын 2023 оны А/183 дугаар тушаалаар оны шилдэг ажилтан, хамт олны шагналд 37,100.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгож зардлын ангилал зөрчсөн. | 1 | 37,100.0 | | | | | 1 | 37,100.0 | | | | |
| ЭХЭМҮТ-ийн захирлын 2023 оны А/01 дүгээр тушаалаар баталсан төвийн орон тоо бүтцэд байхгүй Төгсөлтийн дараах сургалтын хүүхэд судлалын тэнхимийн эрхлэгч, Сувилахуйн тэнхимийн эрхлэгч, Эх баригч эмэгтэйчүүдийн тэнхимийн эрхлэгч болон биеийн тамирын арга зүйч, санхүү эдийн засгийн зөвлөх гэсэн албан тушаалуудад томилон ажиллуулж, нийт 17,267.2 мянган төгрөгийг олгосон. | 1 | 17,267.2 | | | 1 | 17,267.2 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ёс зүйн хорооны гишүүдэд хурлын ирц, гүйцэтгэсэн ажлын тайлангүй сар бүр тогтмол үндсэн цалингийн 10.0-20.0 хувиар тооцож 9,898.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон. | 1 | 9,898.0 | | | 1 | 9,898.0 | | | | | | |
| Өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ажилчид Хөдөлмөрийн дотоод журмын 3.2.2в-д "Ажилтанд тэтгэвэрт гарах үед Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-дахь заалтын дагуу тэтгэмжид хамруулах ба нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно" гэсэн заалт оруулан баталж 70,778.4 мянган төгрөгийн тэтгэмжийг цалингийн сангаас олгосон. | 1 | 70,778.4 | | | 1 | 70,778.4 | | | | | | |
| ЭБЭЭ-н үйлчилгээний талбайн дотор засал болон ЭБЭЭ НҮЗП-ийн зам, талбай ажлыг харьцуулалтын аргаас зайлсхийж хэсэгчлэн хувааж шууд гэрээ байгуулсан. | 1 | 75,864.2 | | | 1 | 75,864.2 | | | | | | |
| Тайлант оны хөрөнгө оруулалт болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 6 ажил үйлчилгээг санхүүжүүлсэн. | 1 | 69,993.0 | | | 1 | 69,993.0 | | | | | | |
| Фамили партнерс ХХК урсгал засварын материал нийлүүлэх гэрээ хийсэн боловч 4,400.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийлүүлж, урсгал засварын зардлаас хөрөнгө бэлтгэсэн. | 1 | 4,400.0 | | | | | 1 | 4,400.0 | | | | |
| **Дүн** | **21** | **1,225,506.0** | | | **12** | **907,828.9** | **9** | **317,677.1** | | | | |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1,725,129.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлээ.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Тайлант онд 1,303,186.0 мянган төгрөгийн 59 орлогын гүйлгээ, 421,943.7 мянган төгрөгийн 15 зарлагын гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулаагүй. | 1 | 1,725,129.8 | 1 | 1,725,129.8 | | |
| **Дүн** | **1** | **1,725,129.8** | **1** | **1,725,129.8** | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| ЭМДЕГ-ын чанарын болон төлбөрийн хяналтаар тус төвийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс */эмчийн болон байцаагчийн хасагдал/* шалтгаалан ЭМДС-аас авах санхүүжилтийг нэхэмжилсэн дүнгээс 2,355,847.8 мянган төгрөг буюу 2.4 хувийн санхүүжилт хасагдсан байна. | 1 | - | | | 1 | - |
| ЭХЭМҮТ нь ТУЗ байгуулаагүй байгаа нь дотоод хяналт тогтолцоо алдагдах эрсдэлтэй байна. | 1 | - | | | 1 | - |
| **Дүн** | **2** | **-** | | | **2** | **-** |
| **Нийт дүн** | **3** | **1,725,129.8** | **1** | **1,725,129.8** | **2** | |